



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/877

Номгон

Аймгийн Засаг даргын Өрхийн эрүүл мэндийн 7  
төвүүдтэй байгуулсан хамтран ажиллах гэрээ  
дүгнэх ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны "Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам" гэрээний загвар, шалгуур үзүүлэлт батлах тухай А/104 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй байгуулсан жил бүрийн гэрээний биелэлтийг дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд:

Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга

Эрүүл мэндийн газрын Анхан шатлалын тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Эх барих эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбооны төлөөлөл

Иргэний нийгмийн төлөөлөл


Нарийн бичгийн дарга: Эрүүл мэндийн газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн

842110981

2.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, гэрээний биелэлтийг дүгнэх үйл ажиллагааг журмын дагуу зохион байгуулж, тайланг аймгийн Засаг даргын дэргэдэх Удирдлагын багт танилцуулахыг Нийгмийн бодлогын хэлтэс /В.Наранчимэг/-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН